| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 33,108.60 | 32,315.53 | 793.07 | 98% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 31,195.40 | 30,598.13 | 597.27 | 98% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 916.00 | 916.00 | 0.00 | 100% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 562.00 | 389.40 | 172.60 | 69% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 122.20 | 104.00 | 18.20 | 85% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 101.00 | 96.00 | 5.00 | 95% |
| 210807 | Газрын төлбөр | 212.00 | 212.00 | 0.00 | 100% |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 107,770.70 | 103,427.90 | 4,342.80 | 96% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 89,872.90 | 85,538.90 | 4,334.00 | 95% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 17,897.80 | 17,889.00 | 8.80 | 100% |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 15,264.10 | 11,709.70 | 3,554.40 | 77% |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 15,264.10 | 11,709.70 | 3,554.40 | 77% |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 12,464.10 | 8,911.80 | 3,552.30 | 71% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,800.00 | 2,797.90 | 2.10 | 100% |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 247,082.30 | 224,937.57 | 22,144.73 | 91% |
| 223001 | Бусад хөрөнгө | 247,082.30 | 224,937.57 | 22,144.73 | 91% |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,120,543.40 | 1,966,770.03 | 153,773.37 | 93% |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,290,377.90 | 1,243,142.58 | 47,235.32 | 96% |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,043,295.60 | 996,060.28 | 47,235.32 | 95% |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 247,082.30 | 247,082.30 | 0.00 | 100% |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 731,475.90 | 667,779.62 | 63,696.28 | 91% |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 731,475.90 | 667,779.62 | 63,696.28 | 91% |
| 33 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 18,939.60 | 18,938.88 | 0.72 | 100% |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 18,939.60 | 18,938.88 | 0.72 | 100% |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 79,750.00 | 36,908.95 | 42,841.05 | 46% |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 66,500.00 | 36,658.95 | 29,841.05 | 55% |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 13,250.00 | 250.00 | 13,000.00 | 2% |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 84,697.81 | -84,697.81 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 68,735.49 | -68,735.49 | |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 0.66 | 0.66 | 0.00 | 100% |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 0.01 | 0.01 | 0.00 | 100% |
| 610001 | Төсвийн байгууллага | 0.01 | 0.01 | 0.00 | 100% |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 0.10 | 0.10 | 0.00 | 100% |
| 620001 | Удирдах ажилтан | 0.01 | 0.01 | 0.00 | 100% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 0.05 | 0.05 | 0.00 | 100% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 0.04 | 0.04 | 0.00 | 100% |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 0.44 | 0.44 | 0.00 | 100% |
| 630 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | 0.29 | 0.29 | 0.00 | 100% |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 0.29 | 0.29 | 0.00 | 100% |
| 631 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА | 0.15 | 0.15 | 0.00 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 0.15 | 0.15 | 0.00 | 100% |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 0.10 | 0.10 | 0.00 | 100% |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 0.01 | 0.01 | 0.00 | 100% |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 0.05 | 0.05 | 0.00 | 100% |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 0.01 | 0.01 | 0.00 | 100% |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 0.01 | 0.01 | 0.00 | 100% |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 0.02 | 0.02 | 0.00 | 100% |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 0.01 | 0.01 | 0.00 | 100% |

## 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | ТЗ цэвэр дүн | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **44,897.78** | -44,897.78 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **44,897.78** | -44,897.78 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **44,897.78** | -44,897.78 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **6,231.33** | -6,231.33 |
| 210401 | Бичиг хэрэг | | **568.00** | -568.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | **4,049.13** | -4,049.13 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | **447.10** | -447.10 |
| 210404 | Ном, хэвлэл | | **1,167.10** | -1,167.10 |
| **2105** | **Нормативт зардал** | | **13,527.80** | -13,527.80 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | **13,272.00** | -13,272.00 |
| 210502 | Хоол, хүнс | | **255.80** | -255.80 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **1,800.00** | -1,800.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | **1,000.00** | -1,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | **800.00** | -800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **550.00** | -550.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | **550.00** | -550.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **22,788.65** | -22,788.65 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | **22,788.65** | -22,788.65 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **44,897.78** | -44,897.78 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **44,897.78** | -44,897.78 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | **44,897.78** | -44,897.78 |

## 3. Аудитын тайлан

### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Дэлгэрэх сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Г.Банзрагч танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 11-ээс 2021 оны 03 дугаар сарын 18-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Уранбилэг гүйцэтгэв.

Дэлгэрэх сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

### 3.2 Сумын ТТЗ-ийн эрх зорилго, хууль эрх зүй.

Эрхэм зорилго: Монгол Улсын анхны ядууралгүй сум болох.

Дэлгэрэх сумын ТТЗ-ийн бүрэн эрхийг “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасан байна. Үүнд:

1. Баг, хорооны Засаг даргын ажлыг чиглүүлэн удирдах;
2. Сум, дүүргийн Засаг дарга нэгээс илүүгүй орлогчтой байх бөгөөд орлогчийг тухайн Хурлын Тэргүүлэгчидтэй зөвшилцөн томилох, чөлөөлөх
3. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх
4. Эрх бүхий байгууллагаас олгосон ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлд заасны дагуу эдэлбэр газар олгох;
5. Албан татвар, төлбөр, хураамж хураах, зохих төсөвт шилжүүлэх ажлыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх арга хэмжээ авах;
6. Нутаг дэвсгэрийнхээ үйлчилгээний байгууллагуудын эрүүл ахуй, ариун цэврийн байдалд хяналт тавьж, үйлчилгээний цагийн хуваарь тогтоох;
7. Хот, тосгоны иргэдийг цэвэр усаар хангах, хог хаягдал, бохир ус зайлуулах, цэвэрлэх, мод, бут, сөөг, жимсний мод тарьж ургуулах, тохижуулах, гудамж талбайг гэрэлтүүлэх, үер усны хамгаалалт, далан суваг барих арга хэмжээ авах, түүнчлэн харьяалах нутаг дэвсгэрт нь барилга байгууламж барих, зам, холбооны шугам өөрчлөхөд оршин суугчдын санал авч шийдвэрлэх;
8. Хууль тогтоомжид заасан бол тухайн нутаг дэвсгэр дэх төсвийн байгууллагын ажилтныг холбогдох дээд байгууллагын удирдлагатай зөвшилцөн томилох, чөлөөлөх;
9. Хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуулийн 64.4, 64.5-д заасан журмын дагуу холбогдох байгууллагад хүргүүлэх;
10. Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Дэлгэрэх сумын ТТЗ нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд сумын үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

Дэлгэрэх сумын ТТЗ-ийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахаад “Дунд” гэж үнэлэв.

### 3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 1,038.7 сая төгрөгийн 2 хувь буюу 20.8 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 2,110.3 сая төгрөгийн 2 хувь 42.2 сая төгрөгөөр тогтоосон нь төлөвлөлтийн үе шатанд тогтоосон суурь үзүүлэлт, хувь хэмжээг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 85.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 69.7 сая төгрөг болж, 16.0 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Касст байгаа бэлэн мөнгө | | | | |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 85.7 | 69.7 | -16.0 | 100 |
| Замд яваа мөнгөн хөрөнгө | | | | |
| Хадгаламж | | | | |
| Дүн | 85.7 | 69.7 | -16.0 | 100 |

*Эх сурвалж Дэлгэрэх сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 26.0 сая төгрөг ОНХС-ийн дансанд, 37.6 сая төгрөг СХС-ийн дансанд, 5.1 сая төгрөг НСС-ийн дансанд, 1.0 сая төгрөг сумын ерөнхий орлогын дансанд байршиж байна.

### 3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 109.5 сая төгрөгөөс 223.2 сая төгрөг болж 113.7 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 1.3 | 68.5 | 67.2 |
| Зээлийн хүүгийн авлага | | | |
| Бусад авлага | 0.4 | 0.8 | 0.4 |
| Зээлийн авлага | 107.8 | 153.9 | 46.1 |
| **Дүн** | **109.5** | **223.2** | **113.7** |

*Эх сурвалж Дэлгэрэх сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Авлагын үлдэгдэлд 1 хүртэлх жилийн насжилттай 68.3 сая төгрөг, 1-2 жилийн насжилттай 508.3 сая төгрөг, 2-3 жилийн насжилттай 154.5 сая төгрөгийн дараах авлага байна. Олон жилийн насжилттай СХС-аас олгосон зээлийн 154.5 сая төгрөгийн авлага байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Ерөнхий боловсролын сургууль нь тайлант хугацааны эцэст авлагатай байгаа ба энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн зарчмыг баримталж ажиллагаагүй байна.*

### 3.5.6 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 255.4 сая төгрөгөөс 329.2 сая төгрөг болж 73.5 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №3 Бараа материалын*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Түүхий эд материал | 20.0 | 31.1 | 11.1 |
| Хангамжийн материал | 233.0 | 295.2 | 62.2 |
| Мал амьтад | 2.4 | 2.9 | 0.5 |
| **Дүн** | **255.4** | **329.2** | **73.8** |

*Эх сурвалж Дэлгэрэх сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Бараа материалын үлдэгдэлд тайлант онд 320.0 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 16.8 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 260.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 2.4 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Засаг даргын тамгын газар*

- *Тайлант оны 10 дугаар сард төсөвт тодотгол хийж тээвэр шатахууны зардлыг 5.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 15.8 сая төгрөг болгон баталсан. Үлдэгдэл өмнөх оноос өссөн, шатахууны талон нөөцөлсөн байна.*
- *Бичиг хэргийн материалын данснаас 4 ширхэг флашыг шаардах хуудсаар данс бүртгэлээс хассан.*
- *Оготно устгагч багажийг данс бүртгэлд тусгаагүй байна.*

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,314.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3,995.1 сая төгрөг болж 1,680.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Биет хөрөнгө | 2,216.0 | 3.892.0 | 1,676.1 |
| Биет бус хөрөнгө | 98.2 | 103.1 | 4.8 |
| **Дүн** | **2,314.2** | **3,995.1** | **1,680.9** |

*Эх сурвалж Дэлгэрэх сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 56.7 сая төгрөг, үнэ төлбөргүй /ОНХС-ийн хөрөнгө оруулалт, ТАХ/ болон хандиваар авсан 1,914.7 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлээр 5.4 сая төгрөгөөр нэмэгдэж, шилжүүлсэн 3.8 сая төгрөг, акталж шилжүүлсэн 100.6 сая төгрөгийн, дахин үнэлгээний хорогдлоор 0.04 сая төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Цэцэрлэг нэг үндсэн хөрөнгөнд ашиглалтын хугацаа тавигдаагүйгээс элэгдэл дутуу тооцогдсон байна.*

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 6.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 9.2 болж, 3.0 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| *Богино хугацаат өр төлбөр дүн* | 6.3 | 9.2 | 3.0 | 100 |
| **Нийт дүн** | 6.3 | 9.2 | 3.0 | 100 |

*Эх сурвалж Дэлгэрэх сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд НДШ, ХХОАТ-ын өглөг, гэрэл цахилгааны өглөг байна. Мөн нийт өглөгийн үлдэгдэлд ээзн холбогдогчгүй сумын ЗДТГ-т 3.2 сая төгрөгийн, ЕБС-д 0.2 сая төгрөгийн өглөг байна.

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5,108.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6,212.1 сая төгрөг болж, 1,103.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, бууралт /-/ | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,149.0 | 1,149.0 | 0.00 | 0% |
| Хуримтлагдсан үр дүн | 986.3 | 2,830.9 | 1,844.6 | 99.7% |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 623.1 | 628.2 | 5.1 | 0.003% |
| Дүн | 2,758.4 | 4,608.1 | 1,849.7 | 100% |

*Эх сурвалж Дэлгэрэх сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Хуримтлагдсан үр дүн 2,830.9 сая төгрөг болж сая төгрөг болж 1,844.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 628.1 сая төгрөг болж 5.1 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь сумын Соёлын төвийн музейн үзвэрийг дахин үнэлсэнтэй холбоотой байна.

### 3.5.10 Орлогын данс

Тайлант онд нийт үйл ажиллагааны мөнгөн орлого 2,068.1 сая төгрөгөөс татварын орлого 63.1 сая төгрөг, татварын бус орлого 37.3 сая төгрөг, тусламж санхүүжилтийн орлого 1,967.7 сая төгрөг төвлөрсөн байна.

### 3.5.11 Зардлын данс

Тайлант онд нийт зардлын дүн 1,802.4 сая төгрөг байгаагаас бараа, ажил үйлчилгээний зардалд 1,734.3 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 68.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Засаг даргын тамгын газар нь НДШ-ийн зардлаас 674.7 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна.*
- *Засаг даргын орлогч Р.Сосорбарамд ХАБ-ын нэмэгдэлд үндсэн цалингаас тооцож 15 хувийн нэмэгдэл 1468.5 мянган төгрөг олгосон байна.*
- *Засаг даргын орлогч Р.Сосорбарамд томилолтын хуудасгүй томилолт олгосон байна.*
- *Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч Ч.Шүрэнцэцэгээс 170.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа суутгаагүй байна.*
- *Засаг даргын тамгын газар цалингийн зардлаас буцалтгүй тусламж олгосон байна.*

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт**

Сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 11/01 дүгээр тогтоолд заасны дагуу Дэлгэрэх сумын ТТЗ нь тайлант онд 41.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 63.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 154 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

| № | Орлогын төрөл | 2020 оны 12 сар тодотгол | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үйл ажиллагааны орлогын албан татвар | 1.3 | 0.2 | - 1.1 | 14% |
| 2 | Бусад татвар | 24.0 | 41.9 | 17.9 | 175% |
| 3 | Бууны татвар | 1.7 | 1.4 | - 0.4 | 78% |
| 4 | Улсын тэмдэгтийн хураамж | 1.5 | 5.4 | 3.9 | 362% |
| 5 | Хог хаягдал үйлчилгээний хураамж | 3.5 | 4.3 | 0.8 | 123% |
| 6 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 0.3 | 0.6 | 0.3 | 183% |
| 7 | Төсөвт байгууллагуудын өөрийн орлого | 0.8 | 0.6 | - 0.1 | 80% |
| 8 | Хадгаламжийн хүүгийн орлого | 8.1 | 8.8 | 0.7 | 109% |
| 9 | Хөрөнгө борлуулсны орлого | 0.1 | 0.6 | 0.5 | 1184% |
| 10 | Хүү торгуулийн орлого | 0.2 | - | - 0.2 | 0% |
| | **Дүн** | **41.3** | **63.7** | **22.4** | **154%** |

- Үйл ажиллагааны орлогын албан татвар 86 хувиар тасарсан нь тайлант оны иргэн, ААНБ-ын үйл ажиллагаатай холбоотойгоор, бууны татвар 22 хувиар тасарсан нь буу

эзэмшигч хасагдсан боловч программаас хасагдаагүй учраас төлөвлөгөө тасарснаар, төсөвт байгууллагын өөрийн орлого 20 хувиар тасарсан нь сумын Соёлын төвийн үйл ажиллагаа цар тахалтай холбоотойгоор хязгаарлагдсан, хүү торгуулийн орлого тайлант онд торгууль тавигдаагүйтэй холбоотой байна.

- Бусад татвар давсан нь тайлант онд арьс шир, ноосны урамшуулал орсноор, улсын тэмдэгтийн хураамж иргэдтэй байгуулсан гэрээг сунгаснаар, хог хаягдлын хураамж иргэн, ААНБ-аас өмнөх оны дутуу төлөлтийг бүрдүүлснээр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр шинээр барилга байгууламж барьсан ААНБ-тай гэрээ байгуулснаар, хөрөнгө борлуулсны орлого иргэдийн хөрөнгийн шилжилттэй холбоотойгоор тус тус давсан байна.

## Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төслийг аудитын явцад ирүүлээгүй байна. Энэ талаар тодруулахад ТТЗ-ийн төсвийн төслийг нэгтгэсэн дүнгээр боловсруулагддаггүй, байгууллага тус бүрээр боловсруулан хүргүүлдэг гэсэн тайлбарыг өгч байна.

## Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 2,120.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,873.5 сая төгрөгийг урсгал зардалд, 247.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,290.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 731.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 18.9 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 79.7 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1,243.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 667.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 18.9 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 36.9 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос, нийт 1,966.7 сая төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 103.7 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 37.2 сая төгрөгөөр давсан нь сум хөгжүүлэх сангийн өмнөх оны үлдэгдлийг батлагдсан төсөвт тусгаж, зээлийн эргэн төлөлтөөс бүрдүүлсэнтэй холбоотой байна.

Туслах үйл ажиллагааны орлого 14.0 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 0.8 сая төгрөгөөр давсан нь тухайн орлогын төлөвлөгөөг БОНСС-ийн эхний үлдэгдлийг орлогоор төлөвлөсөнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,982.7 сая төгрөг буюу 94 хувьтай байгаа нь боловсролын салбарын үйл ажиллагааг хязгаарласантай холбоотойгоор зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдэл 35.0 сая төгрөгийг улсын төсөвт, үндсэн үйл ажиллагааны санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдэл 21.2 сая төгрөг орон нутгийн төсөвт, нийт 56.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 44.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 44.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 153 мэдээллээс 140 мэдээллийг хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид зөрчил арилгах 3 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Биелэгдээгүй | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | | | | | | | |
| Албан шаардлага | 4 | 107.8 | 4 | 107.8 | | | 100 |
| Зөвлөмж | | | | | | | 100 |
| Нийт | 4 | 107.8 | 4 | 107.8 | | | 100 |

Мөн сумын Засаг даргын тамгын газарт өмнөх оны аудитаар 3,850.1 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоосон бөгөөд хэрэгжилт 43.0 хувьтай байна. Төлбөрийн актыг хугацаанд нь барагдуулаагүй 2,194.1 мянган төгрөгийн зөрчил байна. Мөн 9,122.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй байна.

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, орон нутгийн тусгай сангийн нийт 3 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага, 3 сан түүврээр хамрагдсан, 1 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Зөрчилгүй" 3 дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 27,243.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 11,859.4 сая төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 11,991.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, таслах зогсоох, хариуцлага тооцох тухай 2 албан шаардлага хүргүүлж, 3,062.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмжийг хүргүүллээ.

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт №1

## 4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2021 | | | ДГА-2021/12/СТА-ТТЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Дэлгэрэх сумын ТТЗ | | мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчил товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | албан тушаал | овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | ЗДТГ: 2020 оны 10 дугаар сард төсөвт тодотгол хийж тээвэр шатахууны зардлыг 5.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 15.8 сая төгрөг болгон баталсан. Үлдэгдэл өмнөх оноос өссөн, шатахууны талон нөөцөлсөн байна. | | Зөвлөмж өгөх | ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч | Т.Пүрэвсүрэн Э.Баттогоо |
| 2 | ЗДТГ: НДШ-ийн зардлаас 674.7 мянган төгрөгийн цалин хөлс олгосон. | 674.7 | Албан шаардлага өгөх | ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч | Т.Пүрэвсүрэн Э.Баттогоо |
| 3 | ЗДТГ: ЗД-ын орлогч Р.Сосорбарамд ХАБ-ын нэмэгдэлд үндсэн цалингаас тооцож 15 хувийн нэмэгдэл 1468.5 мянган төгрөг олгосон. | - | Зөвлөмж өгөх | ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч | Т.Пүрэвсүрэн Э.Баттогоо |
| 4 | ЗДТГ: Бичиг хэргийн материалын данснаас 4 ширхэг флашыг шаардах хуудсаар данс бүртгэлээс хассан. | 102.9 | Зөвлөмж өгөх | ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч | Т.Пүрэвсүрэн Э.Баттогоо |
| 5 | ЗДТГ: Р.Сосорбарамд томилолтын хуудасгүй томилолт олгосон. | 160.0 | Төлбөрийн акт тогтоох | ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч | Т.Пүрэвсүрэн Э.Баттогоо |
| 6 | ЗДТГ: Ч.Шүрэнцэцэгээс 170.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа суутгаагүй байна. | 170.0 | Төлбөрийн акт тогтоох | ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч | Т.Пүрэвсүрэн Э.Баттогоо |
| 7 | ЗДТГ: Цалингийн зардлаас буцалтгүй тусламж олгосон байна. | 1,010.0 | Зөвлөмж өгөх | ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч | Т.Пүрэвсүрэн Э.Баттогоо |
| 8 | ЗДТГ: Оготно устгагч багажийг данс бүртгэлд тусгаагүй байна. | 1,350.0 | Зөвлөмж өгөх | ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч | Т.Пүрэвсүрэн Э.Баттогоо |
| 9 | ЗДТГ: Өмнөх онд 3,850.1 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоосон бөгөөд хэрэгжилт 43.0 хувьтай байна. Төлбөрийн актыг хугацаанд нь барагдуулаагүй 2,194.1 мянган төгрөгийн зөрчил байна. Мөн 9,122.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн бөгөөд хариу ирүүлээгүй байна. | 11,316.9 | Хариуцлага тооцуулах | ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч | Т.Пүрэвсүрэн Э.Баттогоо |
| 10 | ЗДТГ: Цалингийн тооцоо үүсгээгүй, ажил гүйлгээг мөнгөн сууриар бүртгэснээс авлага 920.5 мянган төгрөгөөр илүү, өглөг 5368.2 мянган төгрөгөөр дутуу тусгасан | 6,288.7 | Аудитын явцад залруулав | ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч | Т.Пүрэвсүрэн Э.Баттогоо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 11 | ЗДТГ: Төлөвлөлтийн үе шатанд 2340. Мянган төгрөгийн шатахууны үнэ, хувь хүнээс суутгасан ОАТ-ын 10 хувь 834.3 мянган төгрөгийг шууд зардалд бүртгэсэн | 3,174.3 | Аудитын явцад залруулав | ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч | Т.Пүрэвсүрэн Э.Баттогоо |
| 12 | ЗДТГ: Төлөвлөлтийн үе шатанд шуудан үйлчилгээний зардлыг цалингийн зардалд бүртгэсэн | 56.4 | Аудитын явцад залруулав | ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч | Т.Пүрэвсүрэн Э.Баттогоо |
| 13 | ЗДТГ: Түлш, шатах тослох материалын бүртгэлийг эд хариуцагчийн тайлантай тулгахад Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулсан 2340.0 мянган төгрөгийг эд хариуцагчийн тайланд тусгаагүй | 2,340.0 | Аудитын явцад залруулав | ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч | Т.Пүрэвсүрэн Э.Баттогоо |
| 14 | ЕБС: Тайлант хугацаанд авлагатай ажилласан байна. | | Зөвлөмж өгөх | Захирал Нягтлан бодогч | М.Ганбаатар Э.Мандхай |
| 15 | Цэцэрлэг: цалингийн дэлгэрэнгүй бүртгэл ирүүлээгүй тул уг горим сорилыг гүйцэтгэх боломжгүй байв. | | Зөвлөмж өгөх | Эрхлэгч Нягтлан бодогч | Б.Энхсайхан Э.Мандхай |
| 16 | Цэцэрлэг Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг давтан шалгахад 1 хөрөнгөд ашиглалтын хугацаа тавигдаагүйгээс элэгдэл тооцогдоогүй байна. | 599.1 | Зөвлөмж өгөх | Эрхлэгч Нягтлан бодогч | Б.Энхсайхан Э.Мандхай |
| **ДҮН** | | **27,243.0** | | | |